



**ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2023 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

**Эрдэм шинжилгээний хурал
зохион байгуулах тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.16 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/445 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Цус сэлбэлт судлалын салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээний ХХ бага хурлын удирдамжийг 1 дүгээр, зохион байгуулах ажлын хэсгийг 2 дугаар, Эрдэм шинжилгээний Бага хурлыг зохион байгуулах, шагнал, өргөмжлөл, бичиг хэргийн зардлын төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Цус сэлбэлт судлалын салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээний ХХ бага хурлыг 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулж, дүнг Удирдлагын зөвлөлд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /М.Цэрэндэжид/-д даалгасугай.

3. Батлагдсан төсвийг төсөл, хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг Санхүү, бүртгэлийн албаны дарга, Ахлах нягтлан бодогч /Х.Одгэрэл/-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитор /С.Алтаннамар/-д үүрэг болгосугай.


ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

1200010793

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн
1162 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН САЛБАРЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХХ БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

Улаанбаатар хот

2023 оны 10 дугаар сарын 04

Үндэслэл:

Дэлхий дахинд жилд дунджаар 170 гаруй орны 12700 гаруй цус цуглуулах төвүүдэд 118.5 сая нэгж цус цуглуулагдаж байна. Монгол Улсын хэмжээнд бүртгэлтэй 159 мянга гаруй цусны донор байна. Сүүлийн 10 жилийн байдлаар Цусны албаны хэмжээнд нийт цус цуглуулалтын тоо 2009 онд 19890 байсан бол 2021 онд 36888 болж 85 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөн нийт доноруудын дунд 2 ба түүнээс дээш удаа цусаа бэлэглэсэн байнгын донорын эзлэх хувь 2009 онд 36% байсан бол 2021 онд 67% болж өссөн үзүүлэлттэй байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс 2003 оноос эхлэн эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж байгаа бөгөөд энэ жил ХХ удаагаа зохион байгуулах гэж байна.

Энэхүү хурлаар цус сэлбэлт судлалын салбарт сүүлийн жилүүдэд хийгдэж буй судалгаа, шинжилгээний ажлуудтай танилцах, харилцан туршлага солилцох, тулгамдсан асуудлыг тодорхойлох, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шинэ, арга технологийг нутагшуулах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд онцгой ач холбогдолтой юм.

Зорилго:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шатлал бүрд ажиллаж буй эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд цус сэлбэлт судлалын салбарт сүүлийн жилүүдэд хийгдэж буй судалгаа, шинжилгээний ажлуудтай танилцах, харилцан туршлага солилцох

Зорилт:

1. Цус цусан бүтээгдэхүүний хэрэгцээ хангамжийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага;

2. Цус, цусан бүтээгдэхүүний эмнэлзүйн зохистой хэрэглээ, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, нотолгоонд тулгуурласан анагаах ухааныг хөгжүүлэх;

Хэзээ: 2023 оны 10 дугаар сарын 04

Хаана: Улаанбаатар хот, БЗД, ЦССҮТ-ийн 403 тоот Хурлын зааланд танхим болон цахим хосолсон хэлбэрээр

Судалгааны материал, арга зүй: Судалгааны загвар, хэрэглэгдэхүүн, хамрах хүрээ, судалгааны арга, мэдээ материал цуглуулсан арга, статистик боловсруулалтын талаар тодорхой бичсэн байна.


Эрдэм шинжилгээний хурлын чиглэлүүд:

- Эмнэлгийн цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ эмчилгээний үр дүн
- Цусны аюулгүй байдал (Haemovigilance)
- Донор зохион байгуулалт, донорын сургалт, сурталчилгаа, маркетинг
- Цус сэлбэлтээр дамжих халдвар
- Цусны ховор бүлгийн тархалт
- Биобэлдмэлийн үйлдвэрлэл
- Эмнэлгийн тоног төхөөрөмж, мэдээллийн технологи
- Нийгмийн эрүүл мэнд

Хамрах хүрээ:


- Эрүүл мэндийн салбарын эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн
- Цус сэлбэлт судлалын салбарын эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн
- Эмнэлзүйн эмч, сувилагч
- Эмгэг судлаач эмч/лабораторийн эмч, мэргэжилтэн
- Био-Анагаахын мэргэжилтэн, судлаач
- Лаборант, техникч
- Эмнэлгийн тоног төхөөрөмж болон мэдээллийн технологийн инженер
- Багш, судлаач

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын
2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн
1162 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



“Цус сэлбэлт судлалын салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд”
эрдэм шинжилгээний ХХ бага хурлыг зохион байгуулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн ахлагч: М.Цэрэндэжид /Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч/
- Гишүүд:
- Ч.Далайцэрэн /ЭШМТА-ны Мэдээллийн, технологийн инженер/
 - Б.Оргил /Үйлдвэрлэлийн тасгийн эрхлэгч/
 - Э.Тунгалагтуяа /Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч/
 - А.Оюунтуяа /Лабораторийн их эмч/
- Нарийн бичгийн дарга: - Э.Энхболор /ЭШМТА-ны Сургалт, төслийн ажилтан/



“Цус сэлбэлт судлалын салбарын олон улсын эрдэм шинжилгээний хурал”-ын төсөв

№	Зардлын төрөл	Зардлын тайлбар	Тоо	Нэгжийн үнэ /Төг/	Нийт үнэ /Төг/
1.	Илтгэлийн хураангуй хэвлэх зардал	Илтгэлийн хураангуй хэвлэх	80	30 000	2 400 000
2.	Зочин шүүгч урьж ажиллуулах зардал	3 хүн	3	100 000	300 000
3.	Шилдэг илтгэлийн шагнал	I байр	1	1 000 000	1 000 000
		II байр	1	800 000	800 000
		III байр	1	500 000	500 000
		Тусгай байр	1	300 000	300 000
4.	Ханын илтгэл	I байр	1	300 000	300 000
6.	Цайны завсарлага	Оролцогчдод	100	7000	700 000
7.	Стенд		1	56 200	56 200
8.	Хэвлэлийн зардал		1	150 000	150 000
Нийт дүн					6 506 200